

Дэлхийн уурхайн компаниуд COVID-19 цар тахлаас ашиг хонжиж байна: хандлага, нөлөөлөл, хариу арга хэмжээ

Уул уурхайн салбар нь дэлхийн хамгийн бохирдолтой, үхэл, сүйрэл авч ирдэг салбаруудын нэг. Гэтэл өнөөдрийг хүртэл COVID-19 цар тахлаас ашиг олох гэсэн уул уурхайн компаниудын үйл ажиллагааг бусад салбартай харьцуулахад маш бага хянаж байна.

Дор гарын үсэг зурсан байгууллагууд бид, уул уурхайн салбар ба засгийн газрууд цар тахлыг ашиглан олборлох шинэ боломжийг бий болгон, одоо болон ирээдүйд олон нийтэд эерэг дүр төрх эсгэх оролдлогыг буруушааж, эсэргүүцэж байна.

Эдгээр ажиллагаа нь олон арван жилийн турш уул уурхайн устгал, сүйтгэлийн эсрэг хийгээд, олон нийтийн эрүүл мэнд, тэдний хүрээлэн буй орчныг хамгаалахын төлөө тэмцэж ирсэн нутгийн хүн ам, байгууллагуудын болоод уурхайн ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд аюул учруулж байна.

Бид нөлөөлөлд өртсөн иргэд, ажилчид, иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн ярилцлагад тулгуурлан хамтын дүгнэлтэд хүрч ийнхүү аюулыг илчилж буй дараах чиг хандлагыг тодорхойллоо. 500 гаруй хэвлэл мэдээллийн эх сурвалж, мэдээ, уул уурхай ба COVID-19-тай холбоотой судалгааны тайлангуудын тойм энэ дүнгэлтийн суурь болсон.

Нэг: Уул уурхайн компаниуд цар тахлын бодит аюулыг үл тоомсорлон, бүхий л арга хэрэгслийг ашиглан үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байна.

Уул уурхайн компаниуд ба олон засгийн газрууд уул уурхайг *чухал үйлчилгээ* гэж ангилан, эрсдлийг үл харгалзан үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх боломжийг олгосоор байна. Ингэснээр тэд вирусын тархалтын гол чиглүүлэгч болж, олон нийт, хот, хөдөөгийн хүн ам, ажиллах хүчнийг ихээхэн эрсдэлд оруулж байна. Ихэнх тохиолдолд уугуул болон хөдөөгийн иргэд нэн ялангуяа уул уурхайн олборлолтоос үүдэлтэй бохирдолд өртөж эрүүл мэнд эмзэг болсон бүлгүүд вирусын хурц эрсдлийг үүрч байна. Энэ үед тэд болзошгүй шинэ дэгдэлтээс өөрсдийгөө хамгаалахын төлөө тэмцэж байна.

Хоёр: Дэлхий даяар улс орны засгийн газрууд хууль ёсны эсэргүүцлийг дарж, уул уурхайн салбарыг дэмжих онцгой арга хэмжээ авч байна.

Олон нийтийн хараа, хяналтаас гадуур засгийн газрууд нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад хүмүүсийн нэгдэх, хөдөлгөөн өрнүүлэх эрх чөлөөг хязгаарлаж байна. Гэвч ийнхүү хатуу, зарим тохиолдолд бүр цэрэгжүүлсэн арга хэмжээ нь хүмүүсийг өөрсдийн нутаг дэвсгэр, амь насаа хамгаалах чадварыг хомсдуулж байна. Газар нутгаа хамгаалагчид зорилгот хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй, зарим нь шударга бусаар шоронд хоригдож байгаа ба халдварын нэмэлт эрсдэлд байна. Засгийн газрууд, ялангуяа компанийн үйл ажиллагаатай удаан хугацаагаар тэмцэж буй бүсэд, хууль ёсны, аюулгүйн шаардлагыг хангасан эсэргүүцлийг няцаах зорилгоор төрийн хүчний байгууллага (цэрэг ба цагдаа) илгээж байна. Эдгээр нь зарим тохиолдолд шүүхээр шийдүүлэх зарчмыг алдагдуулан шүүхэд хүрэх замыг хаах журам, саад тогтоох, мөн тухайн нутагт цэрэг, цагдаагийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх зэргээр илэрч байна. Үүний хажуугаар эдгээр нутагт уул уурхайн компаниудын ажиллагаагаа зөвшөөрөлтэй мөн зөвшөөрөлгүй ч үргэлжлүүлэн явуулсаар байна. Эдгээр болон бусад үйлдлүүд нь ёс зүйгүй ба шударга бусаар уул уурхайн салбарт л ашигтайгаар тусч байна.

Гурав: Уул уурхайн компаниуд нь цар тахлыг бохир ул мөрөө цайруулж, өөрсдийгөө нийтийн төлөө зүтгэгч аврагчийн дүр эсгэхэд ашиглаж байна.

Бүх улс орнууд шашардлагатай сорилын наад захын иж бүрдлийг олж авах гэж шаргуу тэмцэж байхад компаниуд нөлөөлөлд өртсөн нутгийн хүн ам, ажилчиддаа сая саяар нь өөрийн зардлаар авч өгч баярхаж байна. Энэ нь уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр урт удаан хугацаанд эрүүл мэндээр хохироосон буюу эдгээр компанийн өмнөх гар татсан ажиллагааны хохирлыг нөхөх чадваргүй үйлдэл юм. Нийтийн сайн сайхан, нутгийн бүлгүүдэд сорилын иж бүрдлийн хүртээмжийг хангахад чиглэсэн улс орнуудын хамтын хүчин чармайлттай сөргөлдөж үндэстэн дамнасан корпорацууд ба Дэлхийн Өмнөд - хөгжиж буй орнууд хоорондын эрх мэдлийн тэгш бус байдлыг улам тодотгож байна. Зарим тохиолдолд компаниуд хүмүүст шууд хоол хүнс тараах замаар нийгмийн хуваагдал үүсгэж, улмаар өөрийгөө дайчлах боломж муутай цар тахлын үед тайван эсэргүүцлийг сарниулж байна.

Зарим уул уурхайн компаниуд тусламжийн сан байгуулсан буюу төрийн яамдад их хэмжээний хандив өргөсөн байдаг. Эдгээр бэлэн мөнгөн “хандив”-ууд нь тэдний үйл ажиллагааны бодит хөнөөлт нөлөөтэй харьцуулашгүй бага бөгөөд бүр авлигын чанартай нь засгийн газрууд нь онцгой байдлын ажиллагааг сулруулах, авах арга хэмжээг уурхайн бүсэд хэрэгжүүлэхгүй, эсхүл уул уурхайн салбарт огт хамааруулахгүй байгаагаар илэрч байна.

Дөрөв: Уул уурхайн компаниуд болон засгийн газрууд хямралыг ашиглан хүн төрөлхтөн ба Дэлхийн хувь заяанд хохиролтойгоор салбарын сонирхлыг урьдаа тавьсан хуулийн өөрчлөлтийг баталгаажуулж байна.

Уул уурхайг одоогийн болон COVID-19-ийн дараах дэлхийн эдийн засгийн сэргэлтэд чухал үүрэгтэй гэж өргөмжилж, нийгэм, соёл, хүрээлэн буй орчин, эдийн засгийн нөлөөллийг шийдвэрлэх угаас сул тогтолцоог улам сулруулах засаг захиргааны шийдвэрийг түргэтгэн, нөлөөлөлд өртсөн бүлгүүдэд үүрүүлж түүндээ огт шийтгэл хүлээхгүй байхаар лоббидож байна. Байгаль орчны багахан хяналт, хэрэгжүүлэлтийг түр зогсоох эсвэл нөлөөлөлд өртсөн иргэдэд мэдээлэл олж авах, нийгмийн зөвшөөрөл өгөх үйл явцад оролцох замуудыг хаах зэрэг ил, далд маягийн шийдвэрээр засгийн газрууд уул уурхайн салбарт томоохон буултуудыг хийж байгаа бөгөөд харин компаниуд нь ийнхүү зохицуулалтыг бүр байнгын болгохоор засгийн газруудыг лоббидож байна

Үүний зэрэгцээ, компаниуд олон улсын хоёр болон олон талт гэрээ, контрактад ихэд тусгагдсан Хөрөнгө оруулагчид ба Төрийн маргаан таслах (ISDS) механизмыг ахиу ашиглаж, ялангуяа Дэлхийн Өмнөд буурай орны засгийн газруудыг шүүхэд татах явдал нэмэгдэж байна. Тэд засгийн газар, шүүх, тэр байтугай хүний эрхийн байгууллагуудын гаргасан шийдвэрүүдэд олон зуун сая байтугай олон тэрбум долларын нэхэмжлэл гаргах буюу гаргахаар заналхийлж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах шийдвэр гаргах үндэсний тусгаар эрхийг доройтуулж, уурхайн төслүүдээс өөрийгөө хамгаалах хүмүүсийн бие даасан шийдэлд халдаж байна. Хүлээгдэж буй уул уурхайн нийт заргын хэмжээ нь - мэдээлэл байгаа хэсэгтээ - 45.5 тэрбум ам.доллар хүрсэн бөгөөд бодит хэмжээ харьцангуй өндөр байх магадлалтай. Цар тахлын үед авч буй арга хэмжээний хариуд заналхийлэл нэмэгдэх аюул байна.

Өдөр бүр олон нийт, уугуул хүмүүс, газрын эрхээ хамгаалагчид, уурхайн ажилчдад тулгарч буй аюул, эрсдлийг улам бүр нэмэгдүүлж буй **COVID-19 цар тахлын эсрэг ийм хариуг бид түрэмгий үйлдэл хэмээн үзэж буруушааж байна.**

Бид уул уурхайг одоо мөн эдийн засгийн сэргэлтийн хугацаанд нэн чухал үйлчилгээ болно гэх үндсэн санааг няцааж байна. Дэлхийн эрүүл мэнд, эдийн засаг, экологи, цаг уурын давхардсан

хямралтай тэмцэхэд - уул уурхайн араатан мэт корпорацуудын ашиг биш - эрүүл хүн ам, уугуул ард түмэн, ажилчид, нийгмийн хөдөлгөөнүүд зайлшгүй шаардлагатай гэж бид үзэж байна.

Бид үндэсний засгийн газруудад уул уурхайд нэрвэгдсэн хүн ам, уугуул ард түмний өөртөө засах зохион байгуулалт ба өөртөө шийдэх үйл явцыг хүндэтгэн дэмжихийг ***уриалж байна***. Тэдний өөрсдийн мэдлэг, уламжлалд түшиглэсэн хүчин чармайлт нь нийтийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад, мөн түүнчлэн хөдөөгийн жижиг аж ахуй, өөр бүтээлч ажиллагаагаар хөдөө, хот суурин газрын хүн амын хүнсний хараат бус байдалд хүрэхэд амин чухал юм. Эдийн засгийн "идэвхижүүлэлт" нь уул уурхайг дэмжихийн оронд эсрэгээр нийтэд түшиглэсэн санаачлагыг хүлээн зөвшөөрч, дэмжих ёстой.

Цар тахлын үе болон дараах сэргэлтийн үед засгийн газруудаас болон уул уурхайн корпорацуудаас учруулах хүний эрхийн зөрчлүүдэд ***анхаарлаа чанд хандуулж, идэвхтэй буруушаахыг олон улсын хүний эрхийн байгууллагуудад уриалж байна***.

COVID-19-ийн хямрал ба уул уурхайн зүгээс авсан арга хэмжээнд ***хамгийн их өртсөн нутгийн олон түмэн, уугуул хүмүүс, ажилчидтай бид эв санаагаар нэгдэж байна***. Хамтын сайн сайхан, шударга ёсны төлөөх амин чухал кампанит ажилд нь тэднийг дэмжиж ажиллахыг бусдад уриалж байна.

Гарын үсэг зурсан...

Байгууллагууд

Earthworks, АНУ
Institute for Policy Studies, АНУ
London Mining Network, ИБУИНВУ
Mining Watch, Канад
Research and Degrowth (RnD)
Terra Justa
War on Want, ИБУИНВУ
Yes to Life No to Mining, ОУ

[Дараах [link](#)-ээр орж нэгдэнэ үү]